



ARIG GAL
COMPANY

АРИГ ГАЛ ХК-ИЙН
2023 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ



ARIG GAL
COMPANY

“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2023 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД

Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн эрхэм хувьцаа эзэмшигчдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Ингээд, тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагаас хийсэн ажлын тайланг, Та бүхэнд илтгэх ялдамд цаашид ямар зорилго тавьж байгаагаа хүргье.

Тайлангийн хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурлаас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрмийн хүрээнд дараах үйл ажиллагаагаа зохицуулан явууллаа. Үүнд:

Нэг. Борлуулалтын орлогын талаар

Өнгөрсөн онд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2022 онд 1,475.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөгөө 5,7 дахин биелүүлж, 8,444.2 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажиллалаа, Түрээсийн орлого 713,2 сая төгрөгт хүрч төлөвлөсөнөөс 78,3 % -иар өссөн. Өссөн шалтгаан нь Кашмер холдинг ХХК-иар төлөгдөж байсан цахилгаан, дулааны төлбөр 2022 оноос Ариг гал ХК-ийн нэрээр хийгдэж дамжигдсантай холбоотой. Харин ногдол ашгийн орлого төлөвлөснөөс 27%-иар буурсан биелэлттэй байна.

Сүүлийн гурван жилд дэлхий дахинд “Коронавируст халдвар” ихээр тархаж, хөл хорионы улмаас, харьяа компаниудын экспорт бүрэн зогссон, энэхүү вируст халдварын манай улсад бүртгэгдсэн тоо нэмэгдсэнээс дотоод борлуулалт эрс буурснаас шалтгаалан тус компани болон манай хөрөнгө оруулалттай ноолуурыг үйлдвэрлэлийн компаниудын хувьд эдийн засгийн маш хүнд байдалд орж, улмаар банкны зээл, зээлийн хүүгийн дарамтад орж 2019-2020 онд түүхий эд бэлтгэх хэмжээ огцом буурч, энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд компанийн зарим хөрөнгийг эргэлтэд оруулж, санхүүгийн эх үүсвэр олох зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгосон тухай мэдээллийг 2021 оны ээлжит хурлын тайланд оруулж Та бүхэнд мэдээлсэн билээ. Гэвч хаяагүй үйл ажиллагаа зогсонги байдалд орж, хөрөнгийн хомсдолд орсноос

гэрээний дагуу хийгдэх төлбөр хойшилсоор энэ онд цэцэрлэгт хүрээлэнгийн тодорхой хэсгийг худалдсаны орлогоор 7,2 тэрбум төгрөгийн орлого орсон байгаа.

Ингээд 2022 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл болон 2023 оны төлөвлөлтийг танилцуулая:

№	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны		2022 оны		/мян.төг/
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	2023 оны төлөвлөгөө
I	Борлуулалтын орлого	1,090,000.0	2,273,226.4	1,475,000.0	4,201,182.8	5,965,000.0
1	Үүнээс: Түрээсийн орлого	400,000.0	248,807.5	400,000.0	713,228.7	750,000.0
2	Бусдаас авсан ногдол ашиг	675,000.0	1,132,852.2	675,000.0	492,289.7	5,200,000.0
4	Бусад орлого	15,000.0	1,426,881.2	400,000.0	7,238,700.0	15,000.0
II	Зардлын дүн	982,010.0	2,108,509.7	1,141,410.0	5,498,497.3	2,584,424.0
III	Нийт ашиг	107,990.0	700,031.2	333,590.0	2,945,721.1	3,380,576.0
22	Ашгаас санхүүжүүлэх зардал	15,000.0	3,734.0	15,000.0	10,352.0	15,000.0
23	ААНОАТ		142,688.1	50,000.0	692,100.0	200,000.0
24	Цэвэр ашиг	92,990.0	553,609.1	268,590.0	2,243,269.1	3,165,576.0

v

Хоёр. Санхүүгийн байдлын талаар

2022 оны тайлан балансыг харахад авлага өмнөх оноос 33,8 хувиар өссөн. Хэдийгээр Мон ноос ХК-наас 5,6 тэрбум.төг-ийн авлагыг барагдуулсан ч Кашмер холдинг ХХК-ийн түүхий эдийн санхүүжилтэнд 18,2 тэрбум_төг-ийн санхүүжилт өгснөөр авлага өссөн.

Өглөгийн хувьд 24,4%-иар өссөн нь мөн Кашмер холдинг ХХК-д санхүүжилт өгсөнтэй холбоотой Мон ноос ХК-д өгөх өглөгөөр нэмэгдсэн. Мөн 2022 онд валютын огцом өсөлтөөс 4,2 тэрбум төгрөгийн ханшны алдагдал хүлээж өглөг болон ашгийн дүнд нөлөөлсөн. Түрээсийн орлого өмнөх оноос өссөнтэй холбоотойгоор үйл ажиллагааны зардал 51,1% өссөн. Хүүгийн зардал болон бусдаар гүйцэтүүлсэн ажил үйлчилгээний зардал 145,1 сая төгрөгөөр буурсан ч, цалин, НДШ, шатахуун, ашиглалтын зардал 562,2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх онуудад Кашмер холдинг ХХК-иар төлөгдөж байсан цахилгаан, дулааны төлбөрүүд 2022 оноос Ариг гал ХК-ийн нэр дээр хийгдэж эхэлсэнтэй холбоотой ашиглалтын зардал өссөн.

Ногдол ашгийн орлого 492,3 тэрбум төгрөг болон бусад орлого 7,2 тэрбум төгрөг орж ирснийг охин компани болох Кашмер холдинг ХХК-д түүхий эдийн санхүүжилтанд олгосон. Балансын гол үзүүлэлтийн өөрчлөлтийг дараах хураангуй балансаас харна уу.



Ариг гал ХК-ийн 2022 оны жилийн эцсийн хураангуй БАЛАНС

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2021.12.31	2022.12.31	Өсөлт бууралт	
			дүнгээр	хувиар
				/мян.төг/
А.ХӨРӨНГӨ				
1. Эргэлтийн хөрөнгийн дүн	37,902,020.7	52,336,896.4	14,434,875.70	38.1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	45,083.3	1,709,479.6	1,664,396.30	3691.8
Авлага	37,825,904.6	50,600,478.9	12,774,574.30	33.8
Бараа бэлэн бүтээгдэхүүн			-	
Үндсэн туслах материал	31,032.8	26,937.9	(4,094.90)	-13.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			-	
2. Биет хөрөнгийн дүн	2,646,278.7	2,542,738.0	(103,540.70)	-3.9
3. Биет бус хөрөнгийн дүн	527,326.4	525,963.2	(1,363.20)	-0.3
4. Урт хугацаатай хөрөнгө оруулалт	18,230,411.2	18,266,811.1	36,399.90	0.2
Нийт хөрөнгийн дүн	59,306,037.0	73,672,408.7	14,366,371.7	24.2
Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			-	
1. Өр төлбөрийн дүн			-	
Богино хугацаат өр төлбөр	49,756,467.6	61,919,985.8	12,163,518.20	24.4
Урт хугацаат өр төлбөр	563,913.1	797,772.3	233,859.20	41.5
Үүнээс: Банкны хугацаа хэтэрсэн өр			-	
2. Хувьцааны дүн	347,932.0	347,932.0	-	0.0
Халаасны хувьцааны дүн	(9,142.8)	(9,142.8)	-	0.0
3. Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	6,598,730.6	6,598,730.6	-	0.0
4. Хуримтлагдсан ашиг	1,494,527.5	1,773,861.7	279,334.20	18.7
Тайлант үеийн ашиг	553,609.0	2,243,269.1	1,689,660.10	305.2
5. Эзэмшигчийн өмчийн дүн	8,985,656.3	10,954,650.6	1,968,994.30	21.9
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	59,306,037.0	73,672,408.7	14,366,371.7	24.2

ОРЛОГЫН ТАЙЛАН

Санхүүгийн үзүүлэлт	2021.12.31	2022.12.31	Өсөлт бууралт	
			дүнгээр	хувиар
Борлуулалт	248,807.5	713,228.7	464,421.20	186.7
Борлуулалтын хөнгөлөлт урамшуулал			-	
Цэвэр борлуулалт	248,807.5	713,228.7	464,421.20	186.7
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-	
Ашиг	248,807.5	713,228.7	464,421.20	186.7
Үйл ажиллагааны зардал	797,139.3	1,204,584.4	407,445.10	51.1
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	1,244,629.0	3,426,724.8	2,182,095.80	175.3
Үүнд: Ноогдол ашгийн орлого	1,132,852.2	492,289.6	(640,562.60)	-56.5
Хүү, хөрөнгө оруулалтын орлого	1,426,881.3	7,238,700.0	5,811,818.70	407.3
Валютын ханшийн ашиг алдагдал	(535,314.5)	(4,243,035.5)	(3,707,721.00)	692.6
Үйл ажиллагааны бус зардал	(779,790.0)	(61,229.3)	718,560.70	-92.1
Татварын өмнөх ашиг	696,297.2	2,935,369.1	2,239,071.90	321.6
Татвар	142,688.2	692,100.0	549,411.80	385.0
Цэвэр ашиг	553,609.0	2,243,269.1	1,689,660.1	305.2

Ариг гал ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт **1,516,9** сая төгрөгийн татвар шимтгэл төлсөн. Үүнд:

НӨАТатварт - 580,4 сая төгрөг,
 НДШимтгэлд - 78,2 сая.төгрөг,
 Газрын төлбөрт - 103,8 сая төгрөг,
 ҮХХТатварт- 32,0 сая төгрөг,
 ХАОАТатварт - 35,8 сая төгрөг
 ААНОАТатварт - 686,7 сая төгрөг тус тус төлсөн.

Гурав. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилтын биелэлтийн талаар

Ариг гал ХК нь хөрөнгө оруулалттай охин компаниудын үйл ажиллагааг дэмжиж, ажиллах нөхцлийг сайжруулж, хэвийн жигд найдвартай ажиллуулахын тулд КХ ХХК-ийн тусламжтайгаар дараахь ажлуудыг хийж хүлээн авлаа.

1. Ариг гал ХК-ийн дээврийн засварыг 13000 кв талбайд хийж хуучин дээврийн хар цас бетөнөн хучилтын үеийг хуулж бетөнөн тэгшилгээг шинээр хийж праймердаж линокром ЭПП чулуутай хар нааж 148,8 сая төгрөгийн зардлаар хийж гүйцэтгэлээ.
2. Компанийн барилгын баруун талын хананы цонхнуудад вакуум цонх хийж, гадна дотор цонхны амалгаа, өрлөг хийх ажлыг гадны мэргэжлийн компаниар 121,582,200 төгрөгийн зардлаар хийж гүйцэтгүүлснээр будгийн цехийн дулаан алдалтыг зогсоосон.
3. Ариг Гал ХК-ийн Инженерийн байгууламж засвар үйлчилгээг графикийн дагуу хийлгэж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд РП-ээс ТП1 хүртэлх 270 м, 120 кабель солих ажлыг 35 сая төгрөгөөр 10 ква-гийн өндрийн болон 04-ийн шугам тоноглол солих ажилд 18,4 сая төгрөг зарцуулж засвар үйлчилгээг хийж дуусгасан.
4. Эвсэг дэлгүүрийн металл хаалгуудыг солих, үйлдвэрийн зарим цонхны амалгаа хийлгэх, вакуум цонхтой болгох, барилгын гадна ханыг будах, цех захиргааны өрөөний засварт нийт 27,674,596 төгрөгийн зардал гаргаж засвар үйлчилгээ хийлгүүлж хүлээж авсан.
5. Ажилчдын эрүүл мэнд үзлэг үйлчилгээг сайжруулахын тулд массажны өрөө, эмчийн өрөөнд зориулж 18,543,547 төгрөгийн барилгын засвар хийлгэж өрөөг тохижууллаа.
6. Ажилчдын цайны газрыг 23,791,147 төгрөгийн засварыг өөрсдийн ажилчдын хүчээр хийлгэж, тав тухтай тохилог орчныг бүрдүүлж авсан.
7. Ариг Гал ХК-ийн кондициониорин системд 12,4 сая, захиргааны хэсэгт 15,1 сая, дулааны шугам сүлжээнд 12,7 сая, инженерийн шугам сүлжээнд 16,7 сая, цэвэр усны шугам солих ажилд 1,2 сая нийт 58,2 сая төгрөгийг гаргаж өвлийн бэлтгэл ажлыг хийлгүүлсэн.
8. Сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж нарийн номерын утсаар бүтээгдэхүүн хийж дотоодын болон экспэртын захиалгыг нэмж авах зорилгоор Италийн китель 10 ширхэг машиныг 171,087,356 төгрөгөөр худалдан авлаа.
9. Үйлдвэр технологийн дамжлагын хаягдлыг дахин ашиглаж байгаль орчинд ээлтэй эко бордоог угаах машинаас гарсан үе, ноос, лаг, зунгаг, хорголоос гаргаж худалдаанд гаргасан.

10. Гадаад дотоодын зах зээлд ноолууран бүтээгдэхүүний хүүний борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд Италийн болон дотоодын мэргэшсэн дизайнерүүд зөвлөхүүдтэй хамтран ажиллаж “Top Donj” бренд, “Franco Ferraro” бренд, “Alfred Rowland” брендийн шинэ сүлжмэл, ноолууран пальтог гаргахад өөрсдийн хувь нэмрээ оруулж ажилласан.
11. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, менежментийг дэмжиж сайн ажилласан компани, баг, менежерүүдийг шалгаруулж сар бүр ТУЗД-ын нэрэмжит шагналаар давхардсан тоотой 384 ажилтныг 59.1 сая.₮-өөр, жилийн ажлын үр дүнгээр 29 ажилтан 1 багийг тусгай номинацид шалгаруулж нийт 26.5 сая.₮-өөр, бусад ажлын үр дүнгээр 352 ажилтныг 306,8 сая төгрөгөөр урамшуулж, 1 ажилтныг их дээд сургуульд сургаж 2.8 сая.₮-ийн сургалтын төлбөр олгож, орон сууц нийгмийн асуудлыг шийдвэрлэх ипотекийн урьдчилгаанд нийт 21 хүнд 563.6 сая.₮-ийг олгосон болно.
12. Ажилчдын нийгмийн асуудлыг шийдхийн тулд цэцэрлэгийн үйл ажиллагаа, тохижилт үйлчилгээ, хөнгөлөлтийг үзүүлж ажилласан.
13. Нэхэх, хялгас ялгах, оёдлын үйлдвэрлэлүүдийн ажиллах хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхийн тулд 3600 кв талбайг чөлөөлж ашиглалтыг, ажиллах орчин нөхцлийг сайжруулж нүүлгэн шилжүүлэх ажлыг хийсэн бөгөөд хонины ноосон утас хийхэд хэрэглэж байсан хуучин тоног төхөөрөмж, сэлбэгийг худалдан борлуулах ажлыг эхлүүлсэн.

Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэцэд өөрчлөлт ороогүй, ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын Ажлын алба гэсэн бүтцээрээ ажиллаж байгаа.

Ариг гал группийн хэмжээнд Ариг гал ХК-ийн охин компани болох Метро политан проперти ХХК, Блю скай тауэр ХХК, Кашмер холдинг ХХК -иуд үйл ажиллагаагаа явуулсан хэвээр байна. .

Кашмер холдинг ХХК-ийн охин компани болох утас ээрэх үйлдвэрлэлийн Хавт шонхор ХХК, сүлжих үйлдвэрлэлийн Монмяндас ХХК, нэхэх үйлдвэрлэлийн Эвсэг од ХХК, ширмэл үйлдвэрлэлийн Тансаг ширээс ХХК, зөөлөн оёмолын үйлдвэрлэлийн Говийн мяндас ХХК, борлуулалтын Эвсэг ХХК-иуд үйл ажиллагаа явуулж байгаа.

Группийн харъяа компаниудаас хувьцаагаар хөрөнгө оруулалттай Мон ноос ХК, Дорнод ноос ХК, үнэт цаасны арилжаа эрхэлдэг “Аргай бэст ҮЦК” ХХК-иуд нь группийн харъяалалд хамаарагдан өргөн хүрээнд үйл ажиллагааг явуулж байгаа

бөгөөд эдгээрийн сар бүрийн ажлыг ТУЗ-д туслах чиг үүрэгтэй ТУЗ-ийн даргын АА нь дүгнэж байр эзлүүлэн, ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах, сүүлийн байранд орсон компанийн удирдлагад хариуцлага тооцох асуудлыг ТУЗ-ийн даргад тавьж шийдвэрлүүлэх, ажлыг үр дүнтэй явуулах зорилгоор шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, тус шалгуур үзүүлэлтээр компаниудын чадамжийг тогтоож, жилийн ажлаар нь урамшуулан ажилласан.

Ариг гал ХК-ийн ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулан бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого, удирдлагаар хангаж ажилласан.

Тав. Сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар

Тус компани нь Группийн толгой компанийн үндсэн үүргээр ноолуурын үйлдвэрлэлийн охин компаниуд даа ноолуур бэлтгэлийн эргэлтийн хөрөнгө, үйлдвэрлэл өргөтгөх, технологийн сайжруулалт, шинэ тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх үйл ажиллагааны санхүүжилтэд нь зориулж бусад байгууллага, банк, ББСБ-аас зээл олж өгөх, зээлд хөрөнгийн барьцаа, батлан даалт гаргах зэргээр эх орныхоо “сэргээгддэг баялаг” болсон Монгол ямааны ноолуурын боловсруулалтын үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг дэмжих зохицуулалт бүхий бодлогыг баримталж, хэрэгжүүлж ажиллаж ирсэн.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүдийн 55.5% нь өөрийн охин компани болох Кашмер холдинг ХХК-иас сонгогдсон гишүүд байгаагаас дээрх бодлогын хүрээнд охин компаниудад үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх ТУЗ-ийн шийдвэр нь “Компанийн тухай хууль”-ийн 89.1.3 дугаар зүйлд зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож байгаа болно.

Иймд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хурлын хараат бус гишүүдийн 100%-ийн саналаар 05.22 тоот тогтоол гарч, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөр” –ийн хүрээнд “Кашмер холдинг” ХХК-ийн авах 15.0 тэрбум /арван таван тэрбум/-төгрөгийн зээлд “Ариг гал” ХК-ийн 23 нэрийн 65,704,722.0 мянган төгрөг (жаран таван тэрбум долоон зуун дөрвөн сая долоон зуун хорин хоёр мянган)-ийн үнэ бүхий хөрөнгө, хөрөнгийг дагалдуулж газрын эзэмших эрхээр хөрөнгийн барьцаа гаргасныг хувьцаа эзэмшигчдэд тайлагнаж байна. Уг зээлийн эх үүсвэрээр “Кашмер холдинг” ХХК нь ноолуураа бэлтгэж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ явуулж байна.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь

Одоогийн байдлаар компанийн 3749320ш хувьцааг 7272 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа нь өмнөх оноос 1,3%-иар ххувьцаа эзэмшигчдийн тоо буурсан нь хувьцааны төвлөрөл үргэлжилж байгаа гэж харж байна. Компани нь халаасны хувьцааг 9,4%-иар нэмэгдүүлсэн өнөөдрийн байдлаар 3,6%-ийг халаасалсан байгаа.

Тус компанийн хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь Ариг гал группийн харъяа компаниудад ажилладаг ажилтнууд байгаа. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшиж байгаа хэвээр.

Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь тухайн үед мөрдөж байсан үнэт цаасны тухай хуулийн дагуу 1995-онд компанид болон СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа мэдэгдэж бүртгүүлсэн, МХБ-ийн веб сайтад байршуулж нийтэд мэдээлэгдсээр ирсэн.

Компанийн хувьцааны 44.0%-ийн хувьцаа нь 7269 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байна

v

Долоо . Ногдол ашгийн хуваарилалтын тухай

Тус компани жил бүр 100 гаруй сая төгрөгийг ногдол ашигт зарцуулсаар ирсэн.

2020 онд нэгж хувьцаанд 38,93 төгрөг -ийн ногдол ашиг хуваарилж, 135,4 сая.төг-ийг 2022 оны 2 сард багтаан хувьцаа эзэмшигчдэд тараасан, 2021 онд нэгж хувьцаанд 39,90 төгрөг хуваарилж, ногдол ашигт 138,8 сая.төг-ийг 2023 оны 1 сард тараасан.

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 18-ны өдрийн 06/22 тоот тогтоолоор 2022 оны ногдол ашигт нэгж хувьцаанд 67,47 төгрөг хуваарилж, 224,3 сая.төг-ийг зарцуулах бөгөөд өмнөх онуудаас 61%-иар өссөн. Энэ НА-ыг 2023 оны 6 сарын 30-ны дотор нийтэд зарлан тараахаар төлөвлөж байна.

Найм. Цаашид хийх ажил

1. Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч үл хөдлөх хөрөнгө, газар зэргийг барьцаалж, эргэлтийн хөрөнгийн зээл авахад нь дэмжлэг үзүүлж, Монголын ноолууран брендийг бий болгоход хувь нэмрээ оруулах.
2. Ашиглаж чадахгүй, байхгүй, ашиглалтаас гарсан зарим газрыг зарж борлуулан банкны зээл, хүүг төлж барагдуулснаар цаашид банкинд хүү төлөх гэх мэт зардлыг багасгаж ашиг орлогоо нэмэгдүүлэх.

3. Үйлдвэрлэлийн байр талбайг томруулж ажиллах нөхцлийг сайжруулж түрээсийн орлогоо нэмэгдүүлж ажиллах.
4. Ноолуурын хялгас ялгах үйлдвэрлэлийн хүчин чадлыг 2 дахин томсгож 400 тонн ноолуур авах ажилд дэмжлэг үзүүлэх.
5. Монгол ноолууран сүлжмэл хувцас, ноолууран пальто пиджакийг Япон, Солонгос, Англи, АНУ-руу экспортлох ажиллагааг дэмжиж ажиллана.
6. Ээрэх, ороох, машин авах, Итали Япон руу мэргэжилтнүүдээ явуулж мэргэжил дээшлүүлэх ажиллагаанд туслалцаа үзүүлэх.
7. Ариг гал ХК нь үндсэн үйл ажиллагаанаас гадна инженер, ажилтнуудын оролцоотойгоор шинэ бизнесийн судалгаа явуулж эхлээд байгаа бөгөөд ирэх ондоо эдгээр судалгаанд үндэслэсэн шинэ бизнесийг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Үүнд:

- ✓ Анхан шатны үйлдвэрлэлээс гарч байгаа хоёрдогч ашиглан био бордооны үйлдвэрлэл
- ✓ Бүтээгдэхүүн, бусад бараа түгээх хүргэлтийн үйлчилгээ эрхлэх,
- ✓ Бусдын захилгаар барилгын болон барилгын дээврийн засвар үйлчилгээ үзүүлэх г.м мөн судлагдаж байгаа бизнесийн чиглэлүүд дээрээ ажиллаж сонголт хийх болно
- ✓ Эдгээр шинэ бизнесийн судалгаа, сорилтын болон хэрэгжүүлэх аждын санхүүжилт, ноолуурын бэлтгэлийг үйл ажиллагаанд Ногдол ашгаас үлдсэн хэсгийг санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Хүндэтгэсэн: Гүйцэтгэх захирал

Х.Хания

